



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/198

Цагаан-Уул сум

Г 2024 оны цэргийн бүртгэл явуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт, Батлан хамгаалах сайдын 2017 оны А/322 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн тоо бүртгэл зохион байгуулах журам”, аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/651 дүгээр захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны цэргийн бүртгэл явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ш.Эрдэнэцэцэг (Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: А.Энхбаяр (Хэсгийн төлөөлөгч)

Б.Ичинхорлоо (Хууль эрх зүйн мэргэжилтэн)

1 дүгээр багийн Засаг дарга

2 дугаар багийн Засаг дарга

3 дугаар багийн Засаг дарга

4 дүгээр багийн Засаг дарга

5 дугаар багийн Засаг дарга

6 дугаар багийн Засаг дарга

Г.Баярмагнай (Мэдээллийн ажилтан)

Нарийн бичгийн дарга: Ж.Бадрал - (Бичиг хэргийн ажилтан)

2. Хугацаат цэргийн алба хаах насны болон цэргийн бэлтгэл үүрэгтэй иргэдийн цэргийн бүртгэлийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 10-ны дотор зохион байгуулж явуулахыг сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэцэцэг), ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Багийн Засагдарга нарт даалгах нь:

3.1. Дайчилгааны тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, Цэргийн албаны тухай хуулиудад заагдсан “Улсын дайчилгааны төлөвлөгөө”, “Зэвсэгт хүчний анги байгууллагыг хүн хүч, техникээр

хангах төлөвлөгөө”, “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-ний дагуу цэргийн дайчилгааны даалгавар, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн оногдуулан данслагдсан бэлтгэл үүрэгтэй иргэд, авто техник, өөрөө явагч хэрэгсэл, ангийн буу зэргийг нэг бүрчлэн бүртгэн тоолж даалгаваржуулах.

3.2. Бүртгэлийг зохион байгуулахтай холбогдуулан иргэд, цэргийн үүрэгтнүүдэд 2016 онд шинэчлэн батлагдсан “Батлан хамгаалах”-ын багц хууль, 2018 онд батлагдсан “Орон нутгийн хамгаалалтын тухай хууль”, ЗГ-ын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг биеэр хаах журам”, 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Цэргийн гэрээт алба хаах журам” зэрэг хууль эрх зүйн мэдээлэл, цэргийн жинхэнэ алба хаах тухай цахим хэрэгслээр сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг шуурхай зохион байгуулж тайланг 2024 оны 01 дүгээр сарын 05-ны дотор Тамгын газарт ирүүлэх.

4. Цэргийн тоо бүртгэлийг заасан хугацаанд чанартай зохион байгуулан холбогдох байгууллагад 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хүргүүлэхийг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ГОНЧИГНЯМ